



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 13 өдөр

Дугаар А/609

Улаанбаатар хот

Сонгинохайрхан дүүргийн 263 дугаар
цэцэрлэгийн данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 4 дэх заалт болон 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 12 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар хотын хүнсний хог хаягдал дахин боловсруулах төсөл”-ийн хөрөнгөөр нийлүүлсэн нийт 19,163,084.80 (арван есөн сая нэг зуун жаран гурван мянга наян дөрвөн төгрөг наян мөнгө) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлдээ бүртгэн авахыг Сонгинохайрхан дүүргийн 263 дугаар цэцэрлэг (Д.Мөнхзул)-т зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Сонгинохайрхан дүүргийн 263 дугаар цэцэрлэг (Д.Мөнхзул)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

1150501025

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/609 дугаар тушаалын хавсралт

Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Сонгинохайрхан дүүргийн 263 дугаар цэцэрлэг									
№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Ашиглалтад авсан он	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэлд авах		Эх үүсвэр
							Нэгжийн үнэ	Нийт үнэ	
1	Бордоо савлах уутны ам дарагч машин		2024	Шинэ	ш	1	1,483,013.6	1,483,013.6	Улаанбаатар хотын хүнсний хог хаягдлыг дахин боловсруулах төсөл
2	Бордоо боловсруулах дундын эзэмшлийн хайрцаг W2		2024	Шинэ	ш	1	17,680,071.2	17,680,071.2	
Нийт бүртгэх хөрөнгийн дүн								19,163,084.8	